

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/229/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК захирал: О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ОУБ	Олон улсын байгууллага
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ХААИС-ИЙН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМАГ
ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАГДГОЧОО ТАНАА**

2024.08.28 № САА-2024/2029-НА-СӨА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус МСҮТ нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 162 төрлийн 139,418.0 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 747 дугаар тогтоолоор ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож бүртгэл, тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 306 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Шаамар сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг нэгтгэн Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллеж болгон өөрчилсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус МСҮТ нь 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.3 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/
Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	290,176,309.41	272,826,920.85
33	АВЛАГА	91,930.00	41,046.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	41,046.00
335	Бусад авлага	91,930.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	91,930.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	290,084,379.41	272,785,874.85
351	Түүхий эд материал	132,668,702.13	133,744,526.47
35110	Тусгай зориулалттай материал	131,626,982.13	133,284,826.47
35130	Эм боох материал	1,041,720.00	459,700.00
354	Хангамжийн материал	157,415,677.28	139,041,348.38
35410	Бичиг хэргийн материал	289,050.00	357,300.00
35420	Аж ахуйн материал	10,524,369.50	10,193,492.50
35430	Сэлбэг хэрэгсэл	2,089,600.00	-
35440	Түлш, шатах тослох материал	17,432,903.50	8,073,254.50
35450	Барилгын засварын материал	18,313,849.78	7,934,434.78
35460	Хүнсний материал	128,158.00	-
35470	Бусад хангамжийн материал	108,637,746.50	112,482,866.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,525,566,454.06	3,408,957,094.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,525,566,454.06	3,408,957,094.67
392	Биет хөрөнгө	2,778,390,495.52	2,662,758,136.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,473,094,455.84	2,472,951,155.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(379,018,500.36)	(475,315,674.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,953,908.25	116,734,518.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(85,962,525.47)	(93,164,824.19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,049,176,229.42	987,052,390.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(607,390,557.01)	(587,045,741.54)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	198,930,892.33	185,992,874.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(144,284,993.53)	(88,924,577.46)
39209	Зам, гүүрийн байгууламж	40,696,967.89	40,696,967.89
39210	Хуримтлагдсан элэгдэл	(9,785,882.88)	(12,232,353.60)
39217	Ном	114,980,501.04	116,013,400.04
393	Биет бус хөрөнгө	747,175,958.54	746,198,958.62
39301	Программ хангамж	3,908,000.00	3,908,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,104,041.46)	(2,081,041.38)
39303	Бусад биет бус хөрөнгө	744,372,000.00	744,372,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,815,742,763.47	3,681,784,015.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	106,500.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	106,500.00	-
413	Өглөг	106,500.00	-
4136	Бусад өглөг	106,500.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	106,500.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,815,636,263.47	3,681,784,015.52
51	Засгийн газрын хувь оролцоо	3,815,636,263.47	3,681,784,015.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,637,215,244.56	2,637,215,244.56
51101	Өмч:- төрийн	2,637,215,244.56	2,637,215,244.56
512	Хуримтлагдсан үр дүн	(1,056,760,119.72)	(1,168,595,998.95)
51210	Өмнөх үеийн үр дүн	(4,831,361,322.19)	(1,034,743,751.00)
51220	Тайлант үеийн үр дүн	3,774,601,202.47	(133,852,247.95)

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,235,181,138.63	2,213,164,769.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,815,742,763.47</u>	<u>3,681,784,015.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,441,028,506.41	1,695,962,437.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,071,754,859.41	168,948,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,071,754,859.41	168,948,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	4,071,754,859.41	168,948,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,000.00	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,071,681,859.41	168,913,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,369,273,647.00	1,527,014,437.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,154,012,500.00	1,323,017,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,154,012,500.00	1,323,017,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,705,650.00	33,060,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,705,650.00	33,060,920.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	211,555,497.00	170,936,317.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	211,555,497.00	170,936,317.82
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,666,427,303.94	1,820,712,240.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,666,427,303.94	1,820,712,240.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,400,836,671.84	1,723,936,934.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	741,909,137.33	957,378,733.20
210101	Үндсэн цалин	523,727,168.33	716,706,484.48
210102	Нэмэгдэл	135,449,626.00	125,631,329.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,978,200.00	58,328,775.00
210104	Урамшуулал	42,754,143.00	56,712,144.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,598,858.07	119,802,045.23
210201	Тэтгэврийн даатгал	69,567,358.69	83,867,972.89
210202	Тэтгэмжийн даатгал	7,595,897.70	8,537,764.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,969,197.60	5,794,933.34
210204	Ажилгүйдлийн даатгал	1,401,416.82	4,012,555.75
210205	Эрүүл мэндийн даатгал	14,064,987.26	17,588,818.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,531,595.00	173,069,721.82
210301	Гэрэл, цахилгаан	23,638,860.00	31,396,265.82
210302	Түлш, халаалт	98,678,897.00	126,741,946.00
210303	Цэвэр, бохир ус	23,068,878.00	14,931,510.00
210304	Байрны түрээс	1,144,960.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	23,094,144.79	37,954,195.58
210401	Бичиг хэрэг	5,339,837.75	4,097,980.00
210402	Тээвэр, шатахуун	4,684,770.00	3,131,416.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,530,890.00	5,415,752.68
210404	Ном, хэвлэл	20,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,422,000.00	1,400,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,066,447.04	23,908,996.90
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
210408	Бараа материал акталсны зардал	30,200.00	-

2105	Нормативт зардал	15,821,329.00	25,639,484.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,190.00	997,854.00
210502	Хоол, хүнс	15,448,639.00	24,641,630.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	247,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,019,212.00	47,844,332.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	595,000.00	1,167,000.00
210604	Урсгал засвар	16,424,212.00	46,677,332.50
2107	Томилолт, зочны зардал	2,087,200.00	1,888,800.00
210702	Дотоод албан томилолт	2,087,200.00	1,888,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,416,041.00	6,622,624.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	634,000.00	380,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,431,060.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,047,325.00	3,950,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	422,716.00	337,416.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	230,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	66,000.00
210807	Газрын төлбөр	582,000.00	457,948.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	344,359,154.65	353,736,997.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,536,438.09	43,732,822.66
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	316,822,716.56	310,004,175.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,590,632.10	96,775,306.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,681,200.00	57,866,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,897,400.00	42,436,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,833,800.00	14,564,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	950,000.00	865,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	184,194,017.10	38,909,006.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,194,017.10	38,909,006.89
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	715,415.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	715,415.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>3,774,601,202.47</u>	<u>(124,749,803.12)</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	229.50
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	229.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,102,674.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	9,102,674.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(9,102,444.83)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>3,774,601,202.47</u>	<u>(133,852,247.95)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,369,346,647.00</u>	<u>1,527,049,437.82</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	73,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	73,000.00	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,000.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,369,273,647.00	1,527,014,437.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,154,012,500.00	1,323,017,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,154,012,500.00	1,323,017,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,705,650.00	33,060,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,705,650.00	33,060,920.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	211,555,497.00	170,936,317.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	211,555,497.00	170,936,317.82
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,363,908,447.00</u>	<u>1,489,264,947.82</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,363,908,447.00	1,489,264,947.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,098,317,814.90	1,392,581,570.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	745,822,688.28	958,169,552.63
210101	Үндсэн цалин	549,337,442.28	530,034,836.69
210102	Нэмэгдэл	142,387,349.00	267,955,304.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,658,382.00	72,367,999.72
210104	Урамшуулал	23,439,515.00	87,811,411.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,693,843.62	119,050,271.80
210201	Тэтгэврийн даатгал	65,875,720.67	82,321,077.53
210202	Тэтгэмжийн даатгал	7,600,097.50	9,447,205.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,949,038.03	5,801,298.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,382,993.80	2,838,979.02
210205	Эрүүл мэндийн даатгал	13,885,993.62	18,641,711.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	144,667,095.00	163,723,821.82
210301	Гэрэл, цахилгаан	23,638,860.00	31,396,265.82
210302	Түлш, халаалт	96,814,397.00	117,396,046.00
210303	Цэвэр, бохир ус	23,068,878.00	14,931,510.00
210304	Байрны түрээс	1,144,960.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	21,083,603.50	17,651,822.68
210401	Бичиг хэрэг	2,974,699.00	2,334,820.00
210402	Тээвэр, шатахуун	4,684,770.00	3,101,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,530,890.00	5,058,252.68
210404	Ном, хэвлэл	20,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,534,000.00	1,762,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,339,244.50	5,394,450.00
2105	Нормативт зардал	20,514,807.00	28,601,406.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	707,210.00	415,834.00
210502	Хоол, хүнс	14,402,597.00	24,388,372.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,405,000.00	3,797,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,360,280.00	43,748,967.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,780.00	848,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,558,500.00	5,255,250.00

210604	Урсгал засвар	29,758,000.00	37,645,717.50
2107	Томилолт, зочны зардал	2,087,200.00	1,888,800.00
210702	Дотоод албан томилолт	2,087,200.00	1,888,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,557,041.00	6,729,124.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	881,500.00	1,385,086.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	830,060.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,047,325.00	3,950,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	358,216.00	226,078.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	230,000.00	7,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	66,000.00
210807	Газрын төлбөр	540,000.00	264,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,531,256.50	53,017,804.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,531,256.50	53,017,804.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,590,632.10	96,683,376.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,681,200.00	57,774,370.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	41,897,400.00	42,436,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,833,800.00	14,472,470.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	950,000.00	865,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	184,909,432.10	38,909,006.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	184,909,432.10	38,909,006.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,438,200.00</u>	<u>37,784,490.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,438,200.00	37,784,490.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,438,200.00	37,784,490.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,438,200.00	37,784,490.00
223001	Бусад хөрөнгө	5,438,200.00	37,784,490.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,438,200.00)</u>	<u>(37,784,490.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,637,215,244.56	-	(4,831,361,322.19)	(2,194,146,077.63)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,637,215,244.56	-	(4,831,361,322.19)	(2,194,146,077.63)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	2,235,181,138.63	-	2,235,181,138.63
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	3,774,601,202.47	3,774,601,202.47
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,637,215,244.56	2,235,181,138.63	(1,056,760,119.72)	3,815,636,263.47
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	22,016,368.72	22,016,368.72
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,637,215,244.56	2,235,181,138.63	(1,034,743,751.00)	3,837,652,632.19
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(22,016,368.72)	-	(22,016,368.72)
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(133,852,247.95)	(133,852,247.95)
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,637,215,244.56	2,213,164,769.91	(1,168,595,998.95)	3,681,784,015.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,493,953,517.82	1,455,079,510.93	38,874,006.89	97.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,493,953,517.82	1,417,295,020.93	76,658,496.89	94.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,435,982,917.82	1,359,520,650.93	76,462,266.89	94.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	974,200,400.00	958,169,552.63	16,030,847.37	98.4
210101	Үндсэн цалин	531,958,200.00	530,034,836.69	1,923,363.31	99.6
210102	Нэмэгдэл	287,847,600.00	267,955,304.50	19,892,295.50	93.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,368,000.00	72,367,999.72	0.28	00.0
210104	Урамшуулал	82,026,600.00	87,811,411.72	(5,784,811.72)	107.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,775,000.00	119,050,271.80	2,724,728.20	97.8
210201	Тэтгэврийн даатгал	82,807,000.00	82,321,077.53	485,922.47	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	9,742,000.00	9,447,205.00	294,795.00	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,793,600.00	5,801,298.42	1,992,301.58	74.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,948,400.00	2,838,979.02	(890,579.02)	145.7
210205	Эрүүл мэндийн даатгал	19,484,000.00	18,641,711.83	842,288.17	95.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	163,723,821.82	163,723,821.82	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	31,396,265.82	31,396,265.82	-	100.0
210302	Түлш, халаалт	117,396,046.00	117,396,046.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	14,931,510.00	14,931,510.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,011,700.00	13,475,822.68	1,535,877.32	89.8
210401	Бичиг хэрэг	1,866,300.00	1,747,820.00	118,480.00	93.7
210402	Тээвэр, шатахуун	2,748,400.00	2,501,450.00	246,950.00	91.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,719,800.00	4,322,252.68	397,547.32	91.6
210404	Ном, хэвлэл	760,700.00	-	760,700.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,767,300.00	1,762,850.00	4,450.00	99.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,149,200.00	3,141,450.00	7,750.00	99.8
2105	Нормативт зардал	39,712,000.00	28,601,406.00	11,110,594.00	72.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	453,800.00	415,834.00	37,966.00	91.6
210502	Хоол, хүнс	35,331,500.00	24,388,372.00	10,943,128.00	69.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,926,700.00	3,797,200.00	129,500.00	96.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,703,796.00	18,641,646.00	6,062,150.00	75.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,754,800.00	282,600.00	2,472,200.00	10.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,842,900.00	5,255,250.00	3,587,650.00	59.4
210604	Урсгал засвар	13,106,096.00	13,103,796.00	2,300.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,895,100.00	1,888,800.00	6,300.00	99.7
210702	Дотоод албан томилолт	1,895,100.00	1,888,800.00	6,300.00	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,680,500.00	6,568,164.00	112,336.00	98.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,385,700.00	1,385,086.00	614.00	100.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	735,100.00	735,100.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,950,200.00	3,950,200.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	232,100.00	226,078.00	6,022.00	97.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	112,700.00	7,000.00	105,700.00	6.2
210807	Газрын төлбөр	264,700.00	264,700.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,280,600.00	49,401,166.00	38,879,434.00	56.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	88,280,600.00	49,401,166.00	38,879,434.00	56.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,970,600.00	57,774,370.00	196,230.00	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,970,600.00	57,774,370.00	196,230.00	99.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,436,900.00	42,436,900.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,564,400.00	14,472,470.00	91,930.00	99.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	969,300.00	865,000.00	104,300.00	89.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	37,784,490.00	(37,784,490.00)	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	37,784,490.00	(37,784,490.00)	-
222001	Тоног төхөөрөмж	-	31,708,191.00	(31,708,191.00)	-
223001	Бусад хөрөнгө	-	6,076,299.00	(6,076,299.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,493,953,517.82	1,455,079,510.93	38,874,006.89	97.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,323,017,200.00	1,284,108,193.11	38,909,006.89	97.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,323,017,200.00	1,284,108,193.11	38,909,006.89	97.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	170,936,317.82	170,936,317.82	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	170,936,317.82	170,936,317.82	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	35,000.00	(35,000.00)	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	35,000.00	(35,000.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	53.00	53.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	-	100.0
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	303.00	506.00	(203.00)	167.0
632001	Төрийн өмчит МСҮТ	303.00	506.00	(203.00)	167.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	-	-
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	29.00	29.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	23.00	23.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,060,920.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,687,220.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,687,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,176,000.00
210401	Бичиг хэрэг	587,000.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	736,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,253,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,733,621.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	191,700.00
210604	Урсгал засвар	24,541,921.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	94,960.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,616,638.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,616,638.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	373,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	373,700.00
223001	Бусад хөрөнгө	373,700.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,060,920.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,060,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,060,920.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь “Багш, ажилтан, суралцагчдын мэргэжил, ур чадварыг байнга дээшлүүлж тэдний ажиллах ая тухтай таатай орчинг бүрдүүлж ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах,
- Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах,
- Үйлдвэрлэл дээр мэргэжлийн сургалт зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэгдэн батлагдсан
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэгдэн батлагдсан,
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

МСҮТ нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 133,958.75 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	91.93	41.05	(50.88)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	290,084.38	272,785.87	(17,298.50)
Үндсэн хөрөнгө	3,525,566.45	3,408,957.09	(116,609.36)
Нийт хөрөнгө	3,815,742.76	3,681,784.02	(133,958.75)
Өр төлбөр	106.50	-	(106.50)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,815,636.26	3,681,784.02	(133,852.25)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,815,742.76	3,681,784.02	(133,958.75)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Бараа материалын дансны үлдэгдэл 272,785.8 мянган төгрөг болж 17,298.5 мянган төгрөгөөр буурсан нь 16,562.3 мянган төгрөгийн бараа материалыг акталснаас,
2. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,408,957.0 мянган төгрөг болж 116,609.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 37,784.5 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, Мобиком ХК болон Дэлхийн зөн ОУБ-аас 25,295.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авсан болон ТӨБЗГ-ын 2023 оны 12-р сарын 21-ний өдрийн 747 тогтоолоор 63,044.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 162 нэрийн 139,418.0 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлэн, 310,004.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,446,000,0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 198,280.0 мянган төгрөг нийт 2,644,280.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 1,504,670 мянган төгрөгөөр бууруулж 941,330.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 198,280.0 мянган төгрөгөөр, нийт 1,139,610 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур улсын төсвийн санхүүжилтийг 381,687.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт 1,323,017.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 27,343.7 мянган төгрөгөөр бууруулж 170,936.3 мянган төгрөгөөр нийт **1,493,953.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,323,017.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 170,936.3 мянган төгрөг, нийт 1,493,953.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,455,079.5 мянган төгрөгийг зарцуулж, 38,874.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,455,079.5 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 27,734.7 мянган төгрөгөөр, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 10,943.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
	Улсын төсвөөс санхүүжих				
1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,229,715.10	1,201,980.45	27,734.65	97.7
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	57,970.60	57,774.37	196.23	99.7
3	81806 Дотуур байрны үйлчилгээ	35,331.50	24,388.37	10,943.13	69.0
	Дүн	1,323,017.20	1,284,143.19	38,874.01	97.1
	Орон нутгийн төсвөөс санхүүжих				
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	170,936.32	170,936.32	-	100.0
	Дүн	170,936.32	170,936.32	-	100.0
	Нийт дүн	1,493,953.52	1,455,079.51	38,874.01	97.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд аж ахуйн нэгжүүдээс хандив, спорт заалны түрээсийн орлого, бүтээгдэхүүн борлуулсан зэрэг 33,060.9 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	мянган төгрөгөөр /		
		Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Нүүрс	95,172.0	90,617.8	НТШ
	Нийт дүн	95,172.0	90,617.8	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “Эко партнес” ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд хичээл практикийн материал, хүнс, бичиг хэрэг, цэвэрлэгээний материалыг Цахим ертөнц, Алтан Есүй, Сэлэнгэ титан ХХК-иудтай, иргэн Д.Даваасүрэнтэй мах, Д.Мөнхцэцэгтэй хүнсний ногоо авах гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг захирал О.Бурмаа , дараагийн шатны хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, газрын захирал, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийн 1,666,427.30 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,664.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус МСҮТ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 27 төрлийн 170 мэдээлэл байршуулахаас 3 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож, 3 төрлийн мэдээллийг огт оруулаагүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон мэдээллүүд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал – хэтрэлт, хэмнэлтийн тайлбар / 10 дугаар сар /,
- Хагас жилийн санхүүгийн тайлан,
- Хандив тусламжийн орлого.

Огт мэдээлээгүй мэдээллүүд:

- Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан,
- Жилийн санхүүгийн тайлан,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт мах, махан бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэггүй, зах зээл хомс гэх шалтгаанаар хүнсний худалдан авалтыг нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалгүйгээр иргэн Д.Мөнхцэцэг, Д.Даваасүрэн нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Худалдан авах ажиллагааг “Худалдан авах ажиллагааны босго үнийн журам”-ын хүрээнд ил тод, нээлттэй зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Сэлэнгэ аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн

хүнсний худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус МСҮТ-ийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,448.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс давхардуулан олгосон тэтгэмж болон сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх 2 зөрчилд төлбөрийн акт, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, төсвийн байгууллагын мөнгөн кассын журмыг мөрдөн ажиллах 2 зөрчилд албан шаардлага, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, түүнд ногдох НДШ-ийг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв тайлагнаж, тогтоосон хугацаанд төлөх зөрчилд 1 зөвлөмж тус тус өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2469.9	1	2469.9	100
Албан шаардлага	1	413.7	1	413.7	100
Зөвлөмж	1	565.2	1	565.2	100
Нийт дүн	3	3448.8	3	3448.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **994.8** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 204.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 790.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдыг Улаанбаатар хот, аймаг сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд хоолны хөнгөлөлтийн 204.0 мянган төгрөгийг давхардуулан тооцож,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ. 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд **790.8** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсөвт зохицуулалт хийлгэж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэх албан шаардлага хүргүүлэх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон	1	204.0	1	204.0								
Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан	1	790.8			1	790.8						
Дүн	2	994.8	1	204.0	1	790.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил Тоо		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны цахим мэдээлэл									
3 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг огт мэдээлээгүй	1								1
Дүн	1								1
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Хүнсний худалдан авалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулаагүй	1								1
Дүн	1								
Нийт дүн	2								2